



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 1/148

Улаанбаатар хот

Захирамж, захирамжийн зарим
заалт хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2, 63.1.4 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/112 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан жагсаалтын “1” дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/133 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан жагсаалтын “5, 7” дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/197 дугаар захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын “6” дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/390 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын “3” дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1027 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1311 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын “1” дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1228 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725020742

